



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 79

Мандалговь

Хот тохижуулах газрыг татан буулгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Хот тохижуулах газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр татан буулгасугай.

2. Хуулийн этгээдийг татан буулгахтай холбогдон үүсэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СӨД ЭРДЭНЭ

